

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Норов	Дугаар	L185
Оршин суугаа аймаг	Говь-Алтай аймаг	Оршин суугаа сум	Тонхил сум
Төрсөн газар	Тонхил сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Зүйлийн хүрээ	Сүм хийдийн дугаар	ГАТХ 108
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 28	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан



Говь-Алтай аймгийн Тонхил сумын Зүйлийн хүрээ

Асуулт:- Та бидэнд тус сумын нутагт байсан Зүйлийн хүрээний тухай ярьж өгнөүү.

Асуулт:-Зүйлийн хүрээний хамба лам нь хэн гэдэг хүн байв?

Хариулт:-Өвгөн багш гэж хүн байсан юм. Тэр хүнд энэ хүрээний бараг лам нар шавь орсон тийм байсан юм байна лээ.

Асуулт:-Хэд орчим ламтай байсан юм бол?

Хариулт:-Зөвхөн гэлэн нь 1000 хүрч байсан юм.

Асуулт:-Барилга байшингийн хувьд тоосгоор барьсан байсан юм болов уу, модоор барьсан байсан юм болов уу?

Хариулт:-Дандаа тоосгоор барьсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:-Хятад хөх тоосго уу?

Хариулт:-Үгүй, түүхий тоосгоор барьсан байсан юм шиг байна лээ

Асуулт:-Дацан дуганууд нь хэд орчим тоотой байсан юм бол?

Хариулт:-5, 6 дуган. Нэлээн олон дуган байсан юм билээ.Энэ **манба** дацан ч гэх шиг, Нүгнээ ч гэх шиг, цогчэн дуган ч гэх шиг их олон дуган байсан юм билээ шүү.

Асуулт:-Гадуураа хэрмэн хашаатай байсан уу?

Хариулт:-Байгаагүй.

Асуулт:-Олон газраас лам нар, хүүхдүүд ирж ном үздэг байсан уу? Ойр хавийн сүмүүдаас?

Хариулт:-Манай хошуу чинь Төгрөг, Бугат, Дарви гээд нэг хошуу байсан байна шүү. Эднээс чинь цуг манай хошуунд ирж ном үздэг тийм байсан юм.

Асуулт:-Ёст бэйсийн хошуу юу?

Хариулт:-Манайх **Жалчин бэйс** Гомбодоржийн хошуу. Манай хошууны ноён.

Асуулт:-Зүйлийн хүрээ шарын шашин байсан уу?

Хариулт:-Тийм ээ, шарын шажин байсан.

Асуулт:-Уул овоогоо тахидаг тухай ярьж өгөхгүй юу?

Хариулт:-Уул овоо тахидаг, Сэнжитэй, Сэнжитийн дух гэж Алтайн нуруун дээр байдаг Гурын овоо тэрнийг тахидаг. Сутай хайрханыг тахидаг, нуурын хойд талын Тахидаг толгой гээд жаахан толгой байгаа тэрнийг тахидаг.

Асуулт:-Сэнжитийн тэр бургасаа арцаар нь тахидаг байсан гэл үү?

Хариулт:-Өвөрт нь жаахан **дугуй** ногоон арц байдаг юм, тэрүүгээр нь тахидаг. Газрын арцаар тахиж болдоггүй, тэрүүгээр тахидаг. Нэг хонины ууц тавиад, тэгээд эмэгтэй хүн гардаггүй, овоон дээр.Цагаан идээ тавьж тахидаг тийм ёстой байсан юм билээ.

Асуулт:-Сутайг бол цагаан идээгээр тахиж уу, юугаар тахиж уу?

Хариулт:-Сутайг сайн мэдэхгүй байна. Энэ бараг цагаан идээгээр тахидаг байхаа.

Асуулт:-Нөгөө уулыг нь, Тахидаг толгойг?

Хариулт:-Энэ доор мөн энэ цагаан тал дээр энэ нуурын **хойдхон** тал дээр байгаа юм. Энийг зүгээр тэгээд л тахичихдаг.

Асуулт:-Наадах болдог уу овоо тахихаар?

Хариулт:-Бололгүй **яхав**.Морь уралдана.Бөх барилдана.

Асуулт:-Тэмээ уралддаг байсан уу?

Хариулт:-Тэмээ уралддаггүй байсан.

Асуулт:-Лам нар нь барилддаг байсан юм болов уу?

Хариулт:-Лам нар зарим нь барилддаг байсан юм билээ. Барилддаг лам нар байсан юм билээ.

Асуулт:-Нэр алдрыг нь мэдэх үү? Барилддаг лам нараас

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Гунгаа лам, Цэнд гэдэг лам тийм хүн байсан юм билээ, их тэнхээтэй.

Асуулт:-Зүйлийн хүрээний бөх Гунгаа гээд л гараад **ирэх үү?**

Хариулт:-Яг тэгнэ.Гунгаа гэж үхэр үүрч байсан тийм хүн, саяхан үхсэн юмаа, тийм хүн байсан юм.

Асуулт:-Зүйлийн хүрээн дээр худалдаачин хятадууд байсан уу?

Хариулт:-Байсан. 2, 3 пүүс байсан юмуу даа. Энэ урд усны урд талыг дагасан пүүсүүд байсан юм билээ.

Асуулт:-Америкийн пүүс байсан гэсэн үү бас?

Хариулт:-Америкийн **пүүсэрхүү** юм байсан юм билээ. Оросын юу байсан юм билээ.Бас л түүхий эд авдаг байсан юм байлгүй дээ.

Асуулт:-Авсан түүхий эдээ **яахав** Орос руу хойш нь гаргах уу?

Хариулт:-Хойш нь гаргадаг байлгүй

Асуулт:-Тэмээгээр үү?

Хариулт:-Тэмээгээр л гаргадаг байсан байх л даа, тэр үед чинь тэрэг гэж юм байсан биш.

Асуулт:-Америкийн пүүсийн худалдаачин ямар нэртэй хэн гэдэг хүн байсан бол?

Хариулт:-Мэдэхгүй.

Асуулт:-Америкийн пүүс байсан л гэж мэдэх үү?

Хариулт:-Байсан л гэж ярьдаг юм билээ. Чухам ямар хүн ямар нэртэй ямар юм байсныг мэдэхгүй.

Асуулт:-Зүйлийн хүрээн дээр **Ганжуур, Данжуур** гээд том судрууд байв уу?

Хариулт:-Байсан. Цуг байсан юм билээ. Энэ их том хүрээ л дээ, баруун талын.

Асуулт:-Ном судраа **барладаг** бар байсан юм болов уу?

Хариулт:-Байсан байлгүй, **барладаг** байсан байх.

Асуулт:-Эмэгтэй лам байсан уу?

Хариулт:-Байхгүй.

Асуулт:-Барилгыг нь түүхий тоосгоор л барьчихсан байсан уу?

Хариулт:-Түүхий тоосгоор барьсан.

Асуулт:-Монголчууд барьсан уу?

Хариулт:-Монголчууд барьдаг байсан байх.

Асуулт:-Та зүйлийн хүрээний жас, малын талаар ярьж өгөхгүй юу, хэд орчим малтай байсан?

Хариулт:-Түмэн хоньтой болж Гантулга шагнуулж байсан юм билээ, Богдоос.

Асуулт:-Адуу, үхэр, тэмээ, бусад мал байсан юм болов уу?

Хариулт:-Тэмээ 1000 тэмээ ачаа Бээжинд юмуу, хятад руу ачаа гурил будаа тээх гэж жасын юмыг авах гэж 1000 тэмээ хомнож жин тээлгэж байсан юм билээ, тэгж ярилцдаг юм билээ.

Асуулт:-Бээжингээс ачаагаа аваад.

Хариулт:-Бээжингээс авдаг юмуу,

Асуулт:-Энэ Зүйлийн хүрээ хэдэн оны үеэс байхгүй болов?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Энэ чинь 25, 26-ны оны **үед устсан** юм байна.

Асуулт:-37 оноос өмнө устсан юмуу?

Хариулт:-Тийм ээ, өмнө байхгүй болсон.

Асуулт:-Лам нарыг нь барьж хэлмэгдүүлсэн үү, өөрсдөө тарчихсан үү?

Хариулт:-Лам нарыг нь барьж хэлмэгдүүлэлгүй **яахав**

Асуулт:-Хамба лам бүгдийг нь барьчихсан үү?

Хариулт:-Хамба лам нь түрүүнд нь нас барчихсан. Өндөр настай хүн байсан.Ноёны жижиг жаахан хувилгаан гэж хойно байшин нь байдаг юм.Тэрэнд гар хүрдэггүй.Хаалга нь онгойчихсон тийм байшин байна.

Асуулт:-Ноёны гэдэг чинь хошуу ноёны гэсэн үг үү?

Хариулт:-Тийм ээ, хошуу ноёны

Асуулт:-Хошуу ноёны хүү нь хувилгаан хүн байсан юмуу?

Хариулт:-Тийм.Хувилгаан хүн байсан юм гэнэ лээ.

Асуулт:-**Тэр хүн** болохоор хэлмэгдэлтийн үед баригдаад байхгүй болсон үү?

Хариулт:-Хэлмэгдэлтийн үед баригдсан.

Асуулт:-37 оны үед хэлмэгдээд байхгүй болсон лам нарын нэр алдрыг та мэдэх үү?

Хариулт:-Сайн мэдэхгүй байна.Хэлмэгдсэн лам нар ч их байна, муусайн тайж ч их байна.

Асуулт:-Албатай байсан хар хүмүүсийг бас.

Хариулт:-Тийм. Тайж нэртэй л хүн байвал хөрөнгийг нь хураачихдаг, шоронд аваачаад хийчихдэг тийм байсан шүү дээ. Манай аав ч гэсэн шоронд яваад тэр тайж, төрийн хар хүн байсан юм.Тайж нэртэй тийм хүн байсан.Тэгээд тайжуудыг аваачаад шоронд хийчихсэн.Хөрөнгийг нь хураагаад морь малыг нь хураагаад тэгж хэлмэгдүүлж байсан байхгүй юу.

Асуулт:-Зүйлийн хүрээнд цам, **Майдар** гардаг байсан үү?

Хариулт:-Гаралгүй **яахав жил болгон**Майдар эргэнэ гэж байдаг.

Асуулт:-Тэрнийг та **харж байсан** үү?

Хариулт:-Би тэрнийг сайн мэдэхгүй байна.

Асуулт:-Жилд нэг л удаа эргэх үү?

Хариулт:-Нэг л удаа эргэдэг байсан юм билээ.

Асуулт:-Ойр хавийн бүх хүмүүс ирдэг байсан үү?

Хариулт:-Бүгд ирдэг байсан. Майдар т мөргөнө гэж бүр хөдөөний улсууд чинь хэрэг болгож ирдэг байсан юм билээ.

Асуулт:-Майдар ынхаа хувцас багийг өөрсдөө хийх үү?

Хариулт:-Бүгд өөрсдөө хийдэг байсан байлгүй дээ.

Асуулт:-Том **Майдар** эргэдэг талбай байдаг байлаа шүү дээ, хүрээ хийдэд чинь. Тэр нь байдаг юм болов үү?

Хариулт:-Тэр хаа нь эргэж байсан юм мэдэхгүй байна.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:-Зүйлийн хүрээний дээр үед хурал номоо хураад ид байхад нь та лам хуврагуудыг харж байсан уу? хувцас хунар нь ямархуу юм.

Хариулт:-**Лам нарыг нь** харж л байсан. Бага шиг л байсан би.

Асуулт:-Ер нь ямар өнгийн дээлтэй **байхав?**

Хариулт:-Шар дээлтэй, улаан орхимжтой, монгол гуталтай. Лам хүүхэд жаахан **сөртгөр** малгайтай, орой нь жаахан шовгор байсан.Гуншаа малгай гэж адууны дэл шиг ингэсэн юм өмсдөг байсан.

Асуулт:-Зүйлийн хүрээний намар зулын 25 гээд нэг том хурал болдог шүү дээ, тэрнийг та мэдэх үү, яаж ямар жаягтай болдог байсан?

Хариулт:-Ямар ном уншдаг байсан юм мэдэхгүй, манай хөдөөнийхөн ч 25-ныг тэмдэглэдэг байсан шүү дээ.

Асуулт:-Ямархуу маягтай тэмдэглэдэг вэ?

Хариулт:-Ийм хавтгай шанага байсан. Одоо энэ боов тавьчихсан юм шиг юм.**Энэнд** гурилаа сайхан **тавганд нь хийчихээд** ингээд зул гол ороогоод 108 зул.Өнөөхийг чинь дүүрэн хөвөн ороож зул **асаачихаад** тэгээд гадаа асаачихдаг байсан юм.Тэгээд цай, боорцог, идээ будаа тавиад жаахан баяр юмуу даа.

Асуулт:-Зулын 25-нд маань хөгжөөдөг байв уу?

Хариулт:-Хөгшчүүл уншилгүй **яахав.**

Асуулт:-Гадаа 108 зул өргөөд.

Хариулт:-Тийм, гадаа зул өргөчихдөг. Энэн дотор 108 зул өргөөд тэгээд энийгээ **асаачихаад**, тэгээд хоол ундтай, маань уншаад баяр юмуу даа, тийм юм хийчихдэг байсан юм.

Асуулт:-Цагаан сарын үеэр ямархуу хурал ном?

Хариулт:-Цагаан сар яах вэ, цагаан сарын юу гэдэг чинь одоо хурж л байх юм даа, яг тийм л юм хурдаг байсан юм. Хөдөө цагаална гэдэг чинь цагааны ёс ч **яахав**гөлөө босоод гоё **хувцсаа** өмсөөд овоогоо тахиад.Хөдөөнийхөн бол буудлынхаа урд тал дээр овоо **босгочихоод** тэрэндээ жаахан юм залаад, модонд янз бүрийн давуу юм уячихдаг юм.

Асуулт:-Шинийн 1-нд Зүйлийн хүрээний хамба лам хошууныхаа ноёд золгодог байв уу?

Хариулт:-Ноён очиж золголгүй **яахав.**

Асуулт:-Хэн гэдэг хүн байсан юм бол? Хошуу ноён.

Хариулт:-**Жалчин** Гомбодорж гэдэг хүн байсан юм, манай хошууны ноён. Тэрний урд талд Өвгөн ноён гээд ярьдаг л юм байна лээ, тэрнийг нь би сайн мэдэх юм биш.

Асуулт:-Өвгөн хамба багшдаа **Жалчин** Гомбодорж гуай очиж золгодог юмуу?

Хариулт:-Золгоно. Тэр чинь хошууны их том бараг хувилгаан хүн байхгүй юу. Ноёноо хувилгаан гэж байсан юм.Тэр ёстой хувилгаан хүн байсан гэж ярьдаг юм билээ.Идтэй шидтэй тийм хүн байсан гэж ярьдаг юм байна лээ.

Асуулт:-Зүйлийн хүрээ хошуу ноёндoo ч юмуу, Богдын хүрээнд татвар төлдөг байсан уу?

Хариулт:-Тэрнийг сайн мэдэхгүй юмаа, үгүй байхаа. Төлдөггүй байсан байх.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:-Зүйлийн хүрээний лам хуврагууд нь хурлаа хурахаа больсны дараа сүм хийдийг нь яасан бэ? Бурхан шүтээнийг нь.

Хариулт:-Дээд **энээд л** аваачаад л хаясан юм билээ. Газарт л тарсан юм билээ.Өртөө гэж байсан юм даа, өртөө хийдэг улсуудаас оройхон шиг болохоор л 2 хомтой тэмээ авдаг, өглөө авчирч өгдөг, хөлөрчихсөн.Хоёр тэмээгээр ачиж аваачаад хаядаг юм билээ.Тэгээд энэ бурхан чинь саяхан болтол энд хөглөөд байдаг байсан.Онгорхой юм, шүр юм байдаг байсан, одоо газарт дарагдаад яасан юмуу алга болчихжээ.Дарсан гэж хэлэлцдэг юм билээ.

Асуулт:-Зүйлийн хүрээний гол шүтээн нь ямар бурхан байдаг юм бол?

Хариулт:- Майдар **бурханыг** шүтдэг байсан, **Жанрайсэг** бурхан. 9 тохой бурхан байдаг байсан гэж хэлэлцдэг юм билээ.**Жанрайсэг**. 9 тохой өндөр.

Асуулт:-Хэлмэгдэлтийн үед тэр **бурханаа** яасан юм бол?

Хариулт:-Аваачаад л дараад байхгүй юу.

Асуулт:-37 оноос өмнө 20 хэдэн онд байхгүй болсон юм байна?

Хариулт:-Тэгсэн.

Асуулт:-Барилга байшинг нь яасан юм бол?

Хариулт:-Нураагаад юу ч байхгүй.

Асуулт:-Энд тэнд аваачиж юм барьсан уу?

Хариулт:-Үгүй. Барьсан байлгүй, модыг нь түлээд, **хураачихаад байшингий** нураагаад юм хийсэн байлгүй. Хашаа хатгаж байхад цайны хог хөглөөд байдаг юм байна лээ.Доор нь цай хийж байсан юм болов уу.

Асуулт:-Энэ сумын нутагт Зүйлийн хүрээнээс өөр дуган байсан уу?

Хариулт:-Тийм дуган байгаагүй. Жаахан гэр бариад 100 хурал хурчихдаг тиймэрхүү жаахан **хүйтан** нэртэй тийм улсууд байсан юм.